

ᠲᠥᠪ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ
ᠲᠥᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠳᠢᠲᠤᠨ
ᠭᠠᠰᠠᠷ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

2024

ЗУУНМОД



АГУУЛГА

I БҮЛЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	3
II БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЛААР	4
Төв аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	6
Төв аймгийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	6
Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайлангийн аудит	
Засгийн газрын тусгай сан, орон нутгийн тусгай зориулалтын сангуудын санхүүгийн тайлангийн аудит	7
Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудит	8
Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудит	8
Завсрын аудит	9
III БҮЛЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЛААР	9
Төрийн аудитын байгууллагын бодлогоор хийсэн аудит	9
Өөрийн байгууллагын төлөвлөгөөгөөр хийсэн аудит	12
IV БҮЛЭГ. БУСАД АУДИТ, АРГА ХЭМЖЭЭ, ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ	12
Аудитын мөрөөр хийх үйл ажиллагааны чанарыг сайжруулах талаар:	12
Чанарын хяналтын талаар:	
Үүрэг даалгаврын биелэлтийн талаар:	12
V БҮЛЭГ. ДОТООД АЖИЛ	13
Сургалтын талаар	13
Харилцаа, хамтын ажиллагаа	14
Өргөдөл гомдол шийдвэрлэлт	15
Шинэ санаачилга	16
Бусад ажлын хүрээнд	18
VI БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	18
VII БҮЛЭГ. ДҮГНЭЛТ, САНАЛ	18



Товчилсон үг	Товчилсон үгийн тайлал
АТГ	Авлигатай тэнцэх газар
БЗОСК	Барилга захиалагч, орон сууц корпараци
ГНАГ	Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ДАХШҮГ	Дотоод аудит, хяналт-шинжилгээ үнэлгээний газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
ЗХЭЗГ	Захиргаа, хууль эрх зүйн газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ММНБИ	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуй нэгж
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СНАГ	Санхүү, нийцлийн аудитын газар
СХОС	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТБОНӨААН	Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуй нэгж
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗС	Тусгай зориулалттай сан
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХАСХОМ	Хувийн ашиг сонирхлын хөрөнгө орлогын мэдүүлэг
ХБТГ	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЧХХ	Чанарын хяналтын хуудас
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан



НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Төв аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 онд Төрийн аудитын байгууллагын хэмжээнд дэвшүүлсэн "Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангахад харилцагч талуудын оролцоог сайжруулах жил" зорилтын хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 10 зорилт 40 хэрэгжүүлэх арга хэмжээтэй боловсруулан батлуулж, эхний хагас жилд хийхээр төлөвлөсөн ажлыг 100 хувийн биелэлттэй хэрэгжүүлэн ажиллалаа.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр, үйл ажиллагааны тайланг эхний хагас жилээр гаргаж, УАГ-т тогтоосон хугацаанд нь хүргүүлэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэлээ.

Төв аймаг дахь Төрийн аудитын газарт дарга, Тэргүүлэх аудитор 1, аудитын менежер 1, ахлах аудитор 3, аудитор 6, жолооч 1, нийт 12 албан хаагчтай ажиллаж байна.

Албан тушаалын тодорхойлолтод заагдсаны дагуу нягтлан бодогч, архив, бичиг хэргийн ажилтны ажлыг хоёр аудиторт, шилэн данс, харилцаа хамтын ажиллагаа, мэдээлэл технологи хариуцсан ажилтан, нярав, нууц хариуцсан ажилтан, эрх бүхий албан тушаалтан гэсэн ажлуудыг аудиторуудад хариуцуулан ажиллуулж байна.


Нийт албан хаагчдаас 10 нь нягтлан бодогч (мэргэшсэн нягтлан бодогч), 1 эрхзүйч, 1 эдийн засагч мэргэжилтэй аудиторууд ажиллаж байна.

Төрийн аудитын байгууллагад ажилласан хугацаагаар авч үзэхэд 25 хувь нь 5 хүртэл жил, 25 хувь нь 6-10 жил, 33,3 хувь нь 11-15 жил, 16,7 хувийг 16-аас дээш жил ажилласан туршлагатай албан хаагчид байна.



АЛБАН ХААГЧДЫН

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГАД АЖИЛЛАСАН ТУРШЛАГА



Тайлант хугацаанд санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэлийн аудит хийхдээ Төрийн аудит MNS 6817:2020 стандарт, УСНББОУС, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын заавар аргачлалыг мөрдөж ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/153 дугаар тушаалаар батлагдсан Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, МУЕА-ын 2023 оны А/162 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө"-г үндэслэн аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 онд гүйцэтгэх

аудитын төлөвлөгөөг нотлох аудит 6 бүлэг, шууд тайлагнах аудит 14 төлөвлөж баталлаа. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн аудитыг 369 байгууллагыг хамруулан хийж, 206 санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт гарган, 163 санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгалаа. Санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэхэд төрийн аудитын болон хувийн аудитын компанийн нийт 28 аудитор, 108 өдөр ажилласан байна.
- Гүйцэтгэлийн 2, нийцлийн 1 аудитад 504 байгууллага, нэгжийн үйл ажиллагааг хамруулан аудитыг гүйцэтгэж 12 аудитор 85 өдөр ажилласан байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн А/82 дугаар тушаалаар батлагдсан “Аудитын үр өгөөжийн журам”-ын дагуу санхүү болон гүйцэтгэлийн аудитаар санхүүгийн 8,741.3 сая төгрөгийн үр өгөөжийг бүртгэж, 275.9 сая төгрөгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлэн тайлагналаа.

Төв аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 онд төсвөөс авсан нэг төгрөгийн санхүүжилтээр 0,6 төгрөгийн үр өгөөжийг бий болголоо.


Тайлант онд гүйцэтгэсэн аудитаар нийт 141,558.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 57,917.2 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 749.8 сая төгрөгийн зөрчилд 148 төлбөрийн акт, 39,592.8 сая төгрөгийн 190 албан шаардлага, 43,298.2 сая төгрөгийн 410 зөвлөмж, сахилгын шийтгэл ногдуулахаар 18 албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлж, хэрэгжилтийг тооцон ажиллалаа.

Төлбөрийн акт: Тайлант хугацаанд 749.8 сая төгрөгийн 148 төлбөрийн акт тогтоож, өмнөх оны 2.2 сая төгрөг үлдэгдэлтэй байснаас тайлант оны 275.9 сая төгрөг, өмнөх оны 1.1 сая төгрөгийн актыг барагдуулж, 462.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Төлбөрийн актын барагдуулалт 36,8 хувийн хэрэгжилттэй байна.

Албан шаардлага: Тайлант хугацаанд 39,592.8 сая төгрөгийн 190 албан шаардлага бичиж, өмнөх оны 108.1 сая төгрөг үлдэгдэлтэй байснаас тайлант оны 13,980.9 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлж, 25,720.0 сая төгрөгийн албан шаардлагын үлдэгдэлтэй байна. Албан шаардлагын барагдуулалт 35,3 хувийн хэрэгжилттэй байна.

Зөвлөмж: Тайлант хугацаанд 410 зөвлөмж өгөгдөж, 332 хэрэгжиж, 78 зөвлөмжийн үлдэгдэлтэй байна. Зөвлөмжийн хэрэгжилт 71,5 хувиар биелсэн байна.

Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага: Тайлант онд 18 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулахаар албан шаардлага хүргүүлсний 10 хэрэгжиж, 8 хэрэгжээгүй үлдэгдэлтэй байна.



ХОЁР. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЛААР:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.6-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2023 оны А/75 дугаар “Санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай” тушаалын дагуу Төв аймаг дахь Төрийн аудитын газраас 369 шалгагдагч байгууллагын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж, дүн, дүгнэлт гаргалаа.



Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторууд нь 27 сумын төсвийн төвлөрүүлэн захирагч, ЗДТГ, ИТХ, Соёлын төв, ОНХС, ХХС, эмийн эргэлтийн сангууд, байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангуудын санхүүгийн тайланд аудит хийж, Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр Голденпэйж аудит ХХК, Өлзийт экаунт аудит ХХК, Релаэнс секюритиз аудит ХХК-ууд 27 сумын ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв болон зарим улсын төсвийн байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргалаа.

Төрийн аудитын байгууллагаас 2023-2024 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2022 оны А/59 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл", мөн 2022 оны А/89 дүгээр тушаалаар баталсан "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар"-ыг хэрэгжүүлэн ажиллалаа.



Тайлант онд TE3-1, TT3-27, TШ3-220, T3C-105, TБОНӨААН-16 санхүүгийн тайланд fas.audit.mn системийг ашиглан аудитын үе шат бүрээр бүрэн гүйцэтгэж, ахлах аудитор, аудитын менежер, тэргүүлэх аудитор тухай бүрд нь хяналтыг хэрэгжүүлж ажиллалаа.


Үүнээс TE3-1, TT3-27, TШ3-166, T3C 3, TБОНӨААН-9 байгууллагын санхүүгийн тайланд бие дааж санал дүгнэлт гарган, батлагдсан загварын дагуу аудитын тайлан, хураангуй тайланг бэлтгэн, шалгагдагч байгууллагуудад хүргүүлэв.



Аудитаар 206 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаснаас "Өөрчлөлтгүй" 176, "Хязгаарлалттай" 26, "Татгалзсан" 4 санал дүгнэлт өглөө.

Аудитаар илэрсэн 57,917.2 сая төгрөгийн 237 алдааг аудитын явцад залруулж, 737.2 сая төгрөгийн 143 төлбөрийн акт, 18,592.9 сая төгрөгийн 180 албан шаардлага бичигдэж, 39,254.8 сая төгрөгийн 403

зөвлөмж өгч, 18 хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэн, хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Тайлант хугацаанд төлбөрийн актыг 37,4 хувь, албан шаардлагыг 75,2 хувь, зөвлөмжийг 83,5 хувь хэрэгжүүллээ.



2.1.1 Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит

Төв аймгийн ТЕЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймгийн Засаг даргын 2024.04.01-ний өдрийн 01/520 дугаар албан бичгээр ирүүлсэн. ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудитыг хийж, аудитын тайланг дарга, тэргүүлэх аудиторов 2024.04.20-ны А/12 дугаар тушаалаар баталгаажуулан, Аймгийн Засаг даргад 01/259, ИТХ-д 01/258, YAГ-ын Санхүү, нийцлийн аудитын газарт 01/257 дугаар албан бичгээр тус тус хүргүүлээ.

Аудитаар илэрсэн алдаа зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтрээгүй тул “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгөгдлөө. ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн 17,561.9 сая төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 1,098.7 сая төгрөгийн 5 албан шаардлага, 2,348.2 сая төгрөгийн 9 зөвлөмж хүргүүлэв. Тайлант хугацаанд албан шаардлагыг 76,9 хувь хэрэгжүүллээ.




2.1.2. Төв аймгийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Аймгийн төсвийн татварын ба татварын бус орлого төлөвлөснөөс 125,7 хувиар буюу 12,980.8 сая төгрөгөөр давж биелэснээс, 12 нэр төрлийн татварын орлогын төлөвлөгөө 9,584.7 сая төгрөгөөр буюу 6-464 хувиар давж биелсэн байна. Тухайлбал:

- Аймаг, сумдын төсөвт төвлөрүүлэх 2023 оны татварын орлого гүйцэтгэлээр 56,019.3 сая төгрөг, үүнээс татварын буцаан олголт 872.5 сая төгрөгийг хасаж тооцоход 55,146.8 сая төгрөг төвлөрч, төлөвлөснөөс 121 хувиар буюу 9,584.7 сая төгрөгөөр
- Татварын бус орлого 4,874.8 сая төгрөг батлагдснаас 8,270.9 сая төгрөг буюу 3,396.1 сая төгрөгөөр тус тус илүү төвлөрсөн байна.

Аймгийн төсвийн татварын ба татварын бус орлогогийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит



Тайлант онд аймаг, сумдын төсөвт төвлөрүүлэх 12 нэр төрлийн татварын орлогын төлөвлөгөө 9,584.7 сая төгрөгөөр буюу 6-464 хувиар давж биелсэн байна.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.1-д заасны дагуу 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт зарлага тодотгон батлагдсан төлөвлөгөөгөөр 121,177.9 сая төгрөг, гүйцэтгэлээр 100,839.3 сая төгрөгийг зарцуулж, 20,338.6 сая төгрөгөөр дутуу буюу гүйцэтгэл 83,2 хувь байна. Энэ нь хөрөнгийн зардал 14,895.3 сая төгрөгөөр зарцуулагдаагүй, урсгал зардал 3,764.1 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулагдсантай холбоотой байна.

ТЕЗ-ийн э-тайлангийн төсвийн гүйцэтгэлийн тайланд Архуст, Баянхангай, Баяндэлгэр сумын төлөвлөгөө 339,3 сая төгрөгөөр тодотгосон тогтоолоос зөрүүтэй, 7 сумын төлөвлөгөө Сангийн яамны э-тайланд шивснээр 1,059.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.



Төв аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/809 тоот захирамжаар аймгийн ЗДТГ-ын албан хаагчдын 2023 оны үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх хурлыг 2023.12.18-ны өдөр зохион байгуулахад шаардагдах 13.9 сая төгрөгийг хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг шийдвэрлэж Хишиг -Арван ХХК-д шилжүүлэн төсвөөс зориулалт бус зардал гаргасан байна.

Аудитын тайланг 2024 оны 04 дүгээр сарын 25-нд А/265 дугаар албан бичгээр аймгийн Засаг даргад, 01/267 дугаар албан бичгээр аймгийн ИТХ, А/269 дүгээр албан бичгээр УАГ-ын СНАГ-т хүргүүлээ.

2.2. Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайлангийн аудит



Сумдын Засаг дарга буюу ТТЗ-дын 27 санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, аудитын тайлан, гэрчилгээ, төлбөрийн акт, албан шаардлагыг хууль тогтоомж, журмын дагуу гаргаж холбогдох байгууллагын удирдлагуудад хүргүүллээ. Аудитаар бичигдсэн төлбөрийн акт, албан шаардлагыг дарга, тэргүүлэх аудиторов 2024 оны 03 дугаар сарын 25-ний өдрийн А/07 дугаар тушаалаар баталгаажууллаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчдын 27 санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт гаргаснаас 88,8 хувь буюу 24 санхүүгийн нэгтгэсэн тайланд "Өөрчлөлтгүй", 7,4 хувь буюу 2 санхүүгийн нэгтгэсэн тайланд "Хязгаарлалттай", 3,8 хувь буюу 1 санхүүгийн нэгтгэсэн тайланд "Татгалзсан" санал дүгнэлт өгөгдлөө. Аудитаар илэрсэн 2,889.9 сая төгрөгийн алдааг залруулж, 14.4 сая төгрөгийн 4 төлбөрийн акт, 722.2 сая төгрөгийн 12 албан шаардлага, 15,980.8 сая төгрөгийн 43 зөвлөмж өгөгдлөө. Тайлант хугацаанд төлбөрийн актыг 28,2 хувь, албан шаардлагыг 96,7 хувь, зөвлөмжийг 99,9 хувь хэрэгжүүллээ.

2.3 Засгийн газрын тусгай сангийн санхүүгийн тайлангийн аудит




Тайлант онд Засгийн газрын 3 тусгай сангийн санхүүгийн тайлангийн аудитыг fas.audit.mn системийг ашиглан аудитын үе шат бүрээр бүрэн гүйцэтгэж, аудитын менежер, тэргүүлэх аудитор тухай бүрд нь хяналтыг хэрэгжүүлж ажиллалаа. Тусгай зориулалтын сангийн 3 санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" санал, дүгнэлт гаргалаа.

Аудитаар илэрсэн 4,225.7 сая төгрөгийн алдааг залруулж, 21.8 сая төгрөгийн 11 төлбөрийн акт, 2,702.0 сая төгрөгийн 11 албан шаардлага, 6,840.1 сая төгрөгийн 32 зөвлөмж өгөгдлөө. Тайлант хугацаанд төлбөрийн актыг 14,2 хувь, албан шаардлагыг 99,7 хувь, зөвлөмжийг 94,3 хувь хэрэгжүүллээ.



2.4. Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудит

Тайлант онд ТШЗ-ын 322 санхүүгийн тайлангийн аудитыг fas.audit.mn системийг ашиглан аудитын үе шат



бүрээр бүрэн гүйцэтгэж, аудитын менежер, тэргүүлэх аудитор тухай бүрд нь хяналтыг хэрэгжүүлж ажиллалаа. Төсвийн шууд захирагчийн 166 санхүүгийн тайланд

бие дааж санал дүгнэлт гаргаснаас 84,9 хувь буюу 141 санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй", 13,2 хувь буюу 22 байгууллагын санхүүгийн тайланд "Хязгаарлалттай", 1,9 хувь буюу 3 байгууллагын санхүүгийн тайланд "Татгалзсан" санал дүгнэлт өгөгдсөн. 155 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгалаа.

ТШЗ-ын аудитын тайлан, дүгнэлт, төлбөрийн акт, албан шаардлагыг хууль тогтоомж, журам, зааврын дагуу гаргаж холбогдох газруудад нь хүргүүлээ. Аудитаар бичигдсэн төлбөрийн акт, албан шаардлагыг дарга, тэргүүлэх аудиторовын 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар баталгаажууллаа.



ТШЗ-ын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 33,026.1 сая төгрөгийн 195 алдааг аудитын явцад залруулж, 698.6 сая төгрөгийн 123 төлбөрийн акт, 14,252.8 сая төгрөгийн 148 албан шаардлага бичигдэж, 13,923.7 сая төгрөгийн 308 зөвлөмж өгч, 22 хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлээ. Тайлант хугацаанд төлбөрийн актыг 38,1 хувь, албан шаардлагыг 69,9 хувь, зөвлөмжийг 60,0 хувь хэрэгжүүлээ.

2.5. Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудит

Тайлант онд ТӨХК 3, ТӨҮГ 2, ОНӨААН 11, нийт 16 байгууллагын санхүүгийн тайланд аудитыг хугацаанд нь хийлээ. Үүнээс 9 байгууллагын санхүүгийн тайланд санал дүгнэлт гарган, 7 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгалаа. ТБОНӨААН-ийн санхүүгийн тайлангийн аудитаар 7 байгууллагад "Өөрчлөлтгүй", 2 байгууллагад "Хязгаарлалттай" санал дүгнэлт өглөө. Аудитаар бичигдсэн төлбөрийн акт, албан шаардлагыг дарга, тэргүүлэх аудиторовын 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/06 дугаар тушаалаар баталгаажууллаа.



ТБОНӨААН-ын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 213.6 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 2.4 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 163.6 сая төгрөгийн 5 албан шаардлага бичигдэж, 161.8 сая төгрөгийн 11 зөвлөмж өгөгдсөн байна. Тайлант хугацаанд төлбөрийн актыг 100 хувь, албан шаардлагыг 76,2 хувь, зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлээ.

2.6. Завсрын аудит



ТТЗ 14, ОНТС 14, ТШЗ 55, ТБОНӨААН 7 санхүүгийн тайланд завсрын аудит хийх төлөвлөгөө, хуваарийг 2024 оны 6 дугаар сарын 27-нд тэргүүлэх аудитор баталлаа. Завсрын аудитыг 9 дүгээр сард хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЛААР:

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2023 оны А/162 дугаар “Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө батлах тухай” тушаал, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэл, нийцлийн аудитыг гүйцэтгэлээ



Тайлант хугацаанд "Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн", "Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" гүйцэтгэлийн аудит, "Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох" сэдэвт нийцлийн аудитыг стандарт, журам, заавар аргачлалыг мөрдөн хийж, аудитын тайланг холбогдох байгууллагуудад хүргүүлээ.

Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитыг ТТЗ, ТШЗ, ТБОНӨААН, ТЗС-ийн 369 байгууллагын санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан гүйцэтгэлээ.

Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд, түүнчлэн нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, хандивын тайланд дүгнэлт гаргах, Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, Газар олголт, эрх шилжүүлэлтийн байдал сэдэвт аудитыг төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэлийн үе шатанд гүйцэтгэж байна.

Төрийн аудитын байгууллагын бодлогоор хийсэн аудит

3.1. Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд, түүнчлэн нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах

Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд, түүнчлэн нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах сэдэвт аудитын төлөвлөлтийн өмнөх үе шатны ажлыг хэрэгжүүлэн, төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулан 2024 оны 06 дугаар сарын 17-нд батлуулсан. УИХ-ын ээлжит сонгууль 2024 оны 06 дугаар сарын 28-нд зохион байгуулагдах тул гүйцэтгэлийн үе шатны ажлыг хэрэгжүүлэх хугацаа болоогүй байна.



3.2. Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох



ҮАГ-аас ирүүлсэн Төрийн аудитын газруудын “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай” хуулийн хүрээнд дүгнэлт гаргах, аудит хийх үйл ажиллагаанд баримтлах бодлого, арга зүй, Сонгуулийн Ерөнхий хорооны 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн №06 дугаар тогтоолоор баталсан сонгуульд нам, эвсэл болон сонгуулийн тойрогт нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох аргачлалын дагуу үе шатны ажлыг хэрэгжүүллээ. Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нам, эвсэлээс зарцуулах зардлын дээд хэмжээг аймагт 1,620.1 сая төгрөгөөр, сумдад 926.6 сая төгрөгөөр, нэг тойрогт зарцуулах зардлын дээд хэмжээг нэгдүгээр хавсралтаар, аймгийн тойрогт нэг нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг хоёрдугаар хавсралтаар, сумдын тойрогт нэг нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг гуравдугаар хавсралтаар тус тус тогтоож, дарга, тэргүүлэх аудиторовын 2024 оны 05 дугаар сарын 27-ны А/24 дүгээр “Аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох тухай” тушаалаар баталгаажуулан, олон нийтэд мэдээлэл хүргэлээ.

3.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах

Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 01/295 дугаарын албан бичгээр аймаг, сумын ИТХ-ын сонгуультай холбоотой зөвлөмж гаргаж, УИХ-ын сонгуулийн 5-р тойрогт оролцож байгаа МАН, АН-д биечлэн бусад 16 намын сонгуулийн ерөнхий нарийн бичгийн дарга нартай утсаар ярьсны үндсэн дээр албаны мейл хаягаар хүргүүлж, Сонгуулийн тухай хуулийн цаглабарт багтаан холбогдох материалыг ирүүлэх талаар сануулсан. Хуулийн дагуу 2024 оны 06 дугаар сарын 24-нд 11 намын 200 мөрийн хөтөлбөр ирүүлсэнд дүгнэлт гаргах аудитыг хийж байна.



3.4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэлд нэгдэн орсон намуудад иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулах

Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2024.06.14-ний өдрийн 01/295 дугаарын албан бичгээр аймаг, сумын ИТХ-ын сонгуультай холбоотой зөвлөмж гаргаж, УИХ-ын сонгуулийн 5-р тойрогт оролцож байгаа МАН, АН-д биечлэн бусад 16 намын сонгуулийн ерөнхий нарийн бичгийн дарга нартай утсаар ярьсны үндсэн дээр албаны мейл хаягаар хүргүүлж, Сонгуулийн тухай хуулийн цаглабарт багтаан холбогдох материалыг ирүүлэх талаар сануулсан. Хуулийн дагуу 2024 оны 06 дугаар сарын 24-нд 11 намын 200 хандивын тайлан ирүүлсэнд дүгнэлт гаргах аудитыг хийж байна.

3.5. Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, үр дүнг тайлагнах

Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитыг ТТЗ, ТШЗ, ТБОНӨААН, ТЗС-ийн 368 байгууллагын санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан гүйцэтгэж, шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллийг хугацаа хоцроож, мэдээллийг байршуулаагүй зөрчилд 11,361.7 сая төгрөгийн 106 зөвлөмж, 5,423.4 сая төгрөгийн 49 албан шаардлага, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй 3 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүллээ. Санхүүгийн тайлангийн аудитын fas.audit.mn системд шилэн дансны зөрчлийг бүртгэж баталгаажууллаа.



Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны үйл ажиллагаанд хамаарах байгууллагуудын Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээ тайлан байршуулсан байдлыг 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар шалгахад 27 сумын 236 байгууллагын нийт мэдээлбэл зохих 19,824 мэдээлэл байршуулахаас 18,428 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн, 672 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 724 мэдээлэл огт мэдээлээгүй буюу хэрэгжилт 94,7 хувьтай байна.

Улсын төсвийн 46 байгууллагаас мэдээлбэл зохих 3,864 мэдээлэл байршуулахаас 3,672 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн, 92 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 100 мэдээлэл огт мэдээлээгүй буюу хэрэгжилт 96,2 хувьтай байна.

Сумд, байгууллагуудын байршуулаагүй нийт 824 мэдээллүүдийг хариуцсан аудиторууд шаардаж, нөхөн байршуулж, мэдээлүүлж байна.

3.6 Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн

Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн сэдэвт аудитын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөр 2024 оны 05 дугаар сарын 21-нд батлагдаж ирсэн. Тус аудитын нээлтийг 2024 оны 05 дугаар сарын 29-нд аймгийн ХОХБТХ, СТСХ гэсэн байгууллагуудын дарга, мэргэжилтнүүдийг оролцуулан хийж, аудитын талаар мэдээлэл өгсөн. Аудитад шаардлагатай баримт, материалыг аймаг, сумдаас хүлээн авч, горим сорил хэрэгжүүлэн, нотлох баримтуудыг цуглуулж, дүн шинжилгээ хийн, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 100 хувь хэрэгжүүлэв.



Гүйцэтгэлийн аудитын хүрээнд Зуунмод, Сэргэлэн, Дэлгэрхаан, Бүрэн, Баян-Өнжүүл сумдад албан томилолтоор ажиллаж, тулган баталгаажуулалт хийсэн. Аудитын нэгдсэн судалгааг бүрэн хөтлөн, тайлагналын үе шатанд 80 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж байна.

3.7 Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн



Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн сэдэвт аудитын дэд төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулан, үе шатны хяналтаар хянуулж, батлуулсан. Аудитын нээлтийг 2024 оны 03 дугаар сарын 05-нд аймгийн ХОХБТХ, ГХБХБГ, ОНӨГ, БЗОСК гэсэн байгууллагуудын дарга, мэргэжилтнүүдийг оролцуулан хийж, аудитын талаар мэдээлэл өгсөн. Баянчандмань, Борнуур, Жаргалант, Зуунмод сумдад ажиллаж, хөрөнгө оруулалтын ажлыг тулган баталгаажууллаа. Гүйцэтгэлийн аудитын тайлан, нэгдсэн судалгааг

2024 оны 04 дүгээр сарын 20-нд УАГ-ын ГНАГ, аймгийн ИТХ, Засаг дарга, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн сэдэвт аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулан баталж, аудитын гүйцэтгэлийн үе шатны ажлыг бүрэн гүйцэтгэж, аудитын тайланг 2024 оны 06 дугаар сарын 24-нд 01/305



дугаар албан бичгээр аймгийн ИТХ-д, 01/302 дугаар албан бичгээр Засаг дарга, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн сэдэвт аудитын хоёр тайланг дарга, тэргүүлэх аудиторов 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/15 дугаар тушаалаар баталгаажууллаа.

Аудитаар 12.6 сая төгрөгийн 5 төлбөрийн акт, 20,999.9 сая төгрөгийн 8 албан шаардлагыг бичиж, 4043.4 сая төгрөгийн 7 зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй байна.

Байгууллагын өөрийн санаачилгаар хийсэн аудит

3.8. Газар олголт, эрх шилжүүлэлтийн байдал

Аудитын урьдчилсан болон төлөвлөлтийн үе шатны ажлыг хийж гүйцэтгэн, аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, асуудлын шинжилгээг дарга, тэргүүлэх аудитаар батлууллаа. Аудитын нээлтийг Төв аймгийн ГХБХБГ, Татварын хэлтсийн дарга, албан тушаалтан, сумдын ЗД, ИТХ-ын нарийн бичгийн дарга, газрын даамал, татварын байцаагч, Санхүү албаны дарга нарт танхимаар болон цахимаар хийж, аудитын төлөвлөгөө, асуудлын шинжилгээг танилцуулж, аудитад шаардлагатай мэдээ, мэдээлэл холбогдох баримт материалыг цаг хугацаанд ирүүлэх, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан ажлаа зохион байгуулах, хамтарч ажиллах талаар ойлголцолд хүрсэн.



Газар олголт, эрх шилжүүлэлтийн байдал сэдэвт гүйцэтгэлийн аудитын хүрээнд аудиторууд хуваарилагдсан сумдын газрын даамлуудаас газар олголт, эрх шилжүүлэлттэй холбоотой хувийн хэрэг, баримт материалд горим сорил хэрэгжүүлж байна. Аудитыг гүйцэтгэлийн үе шатанд 30 хувьтай хэрэгжүүлж байна.

ДӨРӨВ. БУСАД АУДИТ, АРГА ХЭМЖЭЭ, ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

4.1. Аудитын мөрөөр хийх үйл ажиллагааны чанарыг сайжруулах талаар:

Төв аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг Улсын төсвийн байгууллага, Боловсролын байгууллага, Эрүүл мэндийн байгууллага, Орон нутгийн төсвийн байгууллага, Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудаар тус бүр гарган, аудитын алдаа зөрчлийн нэгтгэл хийж, ҮАГ-ын СНАГ-т хүргүүллээ.

Дараагийн аудитаар анхаарах асуудлын судалгааг нэгтгэн гаргаж, дүн шинжилгээ хийн, анхаарах асуудлуудыг түүвэрлэн завсрын аудит хийхээр хуваарь боловсруулан баталлаа.

4.2. Чанарын хяналтын талаар:

Төрийн аудитын газар нь санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитад тавих чанарын хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд анхаарч ажиллав.

Санхүүгийн тайлангийн аудитын fas.audit.mn системээр ТЕЗ, ТТЗ, ТБОНӨААН, ТШЗ, ЗГТС, ОНТС-ийн нийт 369 санхүүгийн тайлангийн аудитыг бүрэн хийж, үе шат бүрд ахлах аудитор, аудитын менежер, дарга, тэргүүлэх аудитор хяналтыг хийлээ. Хяналтын хуудсыг fas.audit.mn системд бүртгэлээ.

Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйл, МУЕА-ын 2020 оны А/82 дугаар тушаалаар батлагдсан "Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах" журмын дагуу ТШЗ 120 байгууллагын 2023 оны жилийн эцсийн



санхүүгийн тайлангийн аудитыг Голден пэйж аудит ХХК, Өлзийт экаунт аудит ХХК, Релаэнс секюритиз аудит ХХК-уудтай гэрээ байгуулан гүйцэтгүүллээ.



Гэрээт аудитын компаниудын хийсэн санхүүгийн тайлангийн аудитын үе шатны ажлуудад болон аудитын тайлан, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжид гурван шатны хяналтыг хийж, холбогдох санал зөвлөмж өгч, засвар хийлгэн аудитын тайлан, дүгнэлтийг холбогдох газруудад нь хүргүүллээ. Чанарын хяналтын хуудсыг fas.audit.mn системээр хөтлөлөө. Мөн алдаа, зөрчлийн нэгдсэн судалгаануудыг гаргуулан авч нэгтгэн ажиллалаа.

Гүйцэтгэлийн аудитад ахлах аудитор багийн гишүүдийн ажлыг хянаж, нэгтгэн тайланг бичиж байна. Санхүүгийн тайлангийн аудитын хувьд ахлах аудитор бусад аудитортой ижил тоотой аудит гүйцэтгэдэг тул аудиторуудын ажлыг хянах цаг хугацааны хувьд боломжгүй, хувийн аудитын компанийн гүйцэтгэсэн аудитын үе шатны хяналтыг хэрэгжүүллээ.

МУЕА-ын 2020 оны А/82 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу гэрээгээр 2024 оны санхүүгийн тайлангийн аудит гүйцэтгэсэн 3 ХАК-ийн үе шатны ажилд чанарын хяналтыг хийж, гүйцэтгэсэн ажлыг нь дүгнэлээ. Голденпэйж Аудит ХХК 87%, Өлзийт экаунт Аудит ХХК 85%, Релаэнс секюритиз Аудит ХХК 87%-ийн оноотой дүгнэгдсэнийг ХАК-уудын захирлуудад 2024 оны 06 дугаар сарын 27-нд танилцуулан, санхүүгийн тайлангийн аудитын чанарыг дээшлүүлэх, эрсдэл бууруулах талаар зөвлөмж өглөө. Мөн ХАК-д олон байгууллага хуваарилагдсанаас аудитын хугацаа хоцроох, чанаргүй аудит хийх, мэдээ, тайланг зөрүүтэй ирүүлэх зэрэг эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч, хувийн аудитын компаниар 2025 онд гэрээгээр гүйцэтгүүлэх байгууллагын тоог 31,6 хувиар бууруулан 82 болголоо.

МУЕА-ын 2023 оны А/21 дүгээр тушаалаар батлагдсан "Аудитын чанарын хяналтын журам"-ын хавсралт маягтуудыг 2 гүйцэтгэл, 1 нийцлийн аудитын үе шатны ажлыг хянахад хөтөлж баталгаажууллаа. Ахлах аудитор багийн гишүүдийн ажлыг хянаж ЧХХ2.1-ЧХХ2.4 маягтуудыг, аудитын менежер багийн ахлах аудитор болон аудиторуудын ажлыг ЧХХ1, ЧХХ2.1-ЧХХ2.4, ЧХХ3 маягтуудаар тэргүүлэх аудитор аудитын төлөвлөлт болон тайлагналын үе шатны ажлыг хянаж, ЧХХ1, ЧХХ3 маягтаар баталгаажууллаа.

4.3. Үүрэг даалгаврын биелэлтийн талаар:

МУЕА-ын А тушаалуудаас 2024 оны АНТАГ-д хамааралтай 4 тушаалыг хэрэгжүүлэн ажиллаж, 1 дүгээр улирлын биелэлтийг 2024 оны 04 дүгээр сарын 01-нд, 2 дугаар улирлын хэрэгжилтийг 2024 оны 06 дугаар сарын 27-нд цахимаар ДАХШҮГ, ЗХЭЗГ-т тус тус хүргүүллээ.

МУЕА-ын орлогч Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын шуурхай хурлыг 3 удаа хийж, 6 үүрэг даалгавар, Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны 2023 оны зөвлөгөөнөөс өгсөн 4 үүрэг даалгавар өгснийг, хяналтад авч хэрэгжүүлэн ажиллаж, 1 дүгээр улирлын хэрэгжилтийг 2024 оны 04 дүгээр сарын 05-нд, 2 дугаар улирлын хэрэгжилтийг 2024 оны 06 дугаар сарын 26-нд ЗХЭЗГ-т хүргүүллээ.

ТАВ. ДОТООД АЖИЛ

5.1. Сургалтын талаар

Төрийн аудитын байгууллагын сургалт, хөгжлийн 2023-2027 оны стратегид заасан арга зүй, бодлогыг баримтлан байгууллагын 2024 оны дотоод сургалтын төлөвлөгөөг нийт 20 сэдвээр хийхээр төлөвлөгөөг батлуулан 2024 оны 02 дугаар сарын 06-нд ХБТГ-т хүргүүллээ. Тус сургалтын төлөвлөгөөг албан хаагч нараас сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгаа авч, түүний дагуу нэгтгэн боловсруулсан. Дотоод





сургалтын төлөвлөгөөнд эхний хагас жилд хийхээр тусгагдсан 13 сэдвээр сургалтыг хийж, тайланг УАГ-ын ХБТГ-т 2024 оны 07 дугаар сарын 02-нд хүргүүллээ.

УАГ-аас 21 удаагийн сургалт, ММНБИ, Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэнцэх газар, Цахим хөгжлийн яам, Боловсрол шинжлэх ухааны газар, Инженер геодези ХХК зэрэг байгууллагуудын 7 удаагийн сургалтад албан хаагч нар бүрэн хамрагдаж, мэдлэгээ дээшлүүллээ.

5.2. Харилцаа, хамтын ажиллагаа

Харилцаа хамтын ажиллагааны хүрээнд 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын нээлтийг 2024 оны 01 дүгээр сарын 18-нд хийж, 2023-2024 оны аудитын ерөнхий чиглэл, төсөв санхүүгийн хяналт, хариуцлага, эрх зүйн орчны өөрчлөлт, төрийн хэмнэлт болон шилэн дансны хуулийн хэрэгжилт, аудитын шийдвэрийн хэрэгжилт, анхаарах асуудал зэрэг сэдвүүдийн хүрээнд танилцуулга, чиглэл өгч, цахимаар 110, танхимаар 56 албан хаагч хамрагдлаа. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, Газар олголт, эрх шилжүүлэлтийн байдал сэдэвт гүйцэтгэлийн аудитуудын нээлтийг хийж холбогдох байгууллагуудын дарга, мэргэжилтнүүдийг оролцуулан, аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт, анхаарах асуудлыг танилцуулан, харилцан ярилцаж, хамтран ажиллалаа.



Эрүүл мэндийн газраас 2024 оны 03 дугаар сарын 29-нд зохион байгуулсан Эрүүл мэндийн салбарын дарга, нягтлан бодогч оролцсон 54 албан хаагч нарт "Санхүүгийн тайлангийн аудитын дүнг танилцуулан, аудитын шийдвэрийг биелүүлэх, анхаарах асуудал" сэдвээр танилцуулга, сургалт хийлээ.

УАГ-аас "Төрийн аудит иргэдийн амьдралд" танилцуулга материал ирүүлснийг 129 төрийн албан хаагч болон иргэдэд тарааж, сурталчлан танилцуулж ажиллалаа.

Тайлант хугацаанд гүйцэтгэсэн аудитын 209 тайланг open.audit.mn нээлттэй портал сайтад, 3 тайланг байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлэл хүргэлээ.

Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 онд гүйцэтгэсэн аудитын зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийн тайлан, 2024 оны 1 дүгээр улиралд хийж гүйцэтгэсэн аудитын шийдвэрийн тайланг 2024.03.29-ны 01/244 дүгээр албан бичгээр, 2 дугаар улиралд хийж гүйцэтгэсэн аудитын шийдвэр, биелэлтийн тайланг 2024.06.26-нд 01/312 дугаар албан бичгээр аймгийн ИТХ-ын дарга, 01/311 дүгээр албан бичгээр ТЕЗ-чид хүргүүллээ.

Прокурорын байгууллагад өмнөх оны шийдвэрийн дутуу үлдэгдлийг барагдуулахад хамтран ажиллах хүсэлтийг 2024 оны 06 дугаар сарын 24-нд А/313 дугаар албан бичгээр хүргүүллээ.

2024 оны санхүүгийн тайлангийн аудитын акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, биелэлтийг fas.audit.mn системд оруулж, хэрэгжилтийг шалгагдагч байгууллагын нягтлан бодогч, холбогдох албан тушаалтнаар гаргуулж, нотлох баримтыг хавсаргуулан хяналт тавин байнгын харилцаатай ажиллаж байна.

2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 717.9 сая төгрөгийн 142 төлбөрийн акт, 16,768.5 сая төгрөгийн 195 албан шаардлага бичигдэж, 34,111.9 сая төгрөгийн 445 зөвлөмж өгч, 13.5 сая төгрөгийн 22 хариуцлага тооцуулах санал, гүйцэтгэлийн аудитаар 12.6 сая төгрөгийн 5 төлбөрийн акт, 20,999.9 сая төгрөгийн 8 албан шаардлага, 5 зөвлөмж бичиж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Харилцагч байгууллагуудтай үр дүнтэй хамтарч ажилласанаар аудитын шийдвэрийн хэрэгжилт 49,8 хувьтай, хугацаа болоогүй шийдвэр 35,0 хувьтай байна.



Харилцагч байгууллагын удирдлага, нягтлан бодогч нараас Төв ТАГ-ын албан хаагчдын ёс зүй, мэдлэг чадвар, авлига ашиг сонирхлын талаар санал асуулга авч байна. Төв аймаг дахь Төрийн аудитын газрын эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан, хураангуй тайланд авлигын хор хөнөөл, авлигыг мэдээлэх 110 дугаарыг арын хуудсанд бичиж, олон нийтэд сурталчилгаа хийлээ.

Шалгагдагч байгууллагын эрх ашиг нь хөндөгдөж байгаа албан тушаалтан нарт сонсох ажиллагаа хийж мэдэгдэх хуудсыг хүргүүлж, хариу тайлбар авч, ажиллалаа.

5.3. Өргөдөл гомдол шийдвэрлэлт

Архив, албан хэрэг хөтлөлтийн хүрээнд 2024 оны 2 дугаар улирлын байдлаар холбогдох хууль, журмын дагуу А тушаал 19, Б тушаал 7 гаргаж албажуулав. Холбогдох байгууллага албан тушаалтанд 313 албан бичгийг хүргүүлж ажиллав. Байгууллагад ирсэн 230 албан бичгийг бүртгэж, үүнээс хариутай 5 албан бичгийн холбогдох байгууллагад хариуг хугацаанд нь хүргүүллээ.

Төлбөрийн акт 142, албан шаардлага 195, аудитын гэрчилгээ 206-г гаргаж батлагдсан индексээр дугаарласан албаны хэвлэмэл хуудас ашиглан, аудитуудын хувийн дугаараар акт, албан шаардлагыг дугаарлан холбогдох байгууллагуудад хүргүүллээ. 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын баримтуудыг түр болон байнга хадгалах хадгаламжийн нэгжээр нь төрөлжүүлэн ангилж, хадгаламжийн нэгжийг цаасан болон цахим архив үүсгэн хадгалахад бэлэн болгоод байна.

ҮАГ-аас баталсан 2024 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалт ирүүлсний дагуу албан хэрэг хөтлөлтийг эрхэлж байна.



Тайлант хугацаанд иргэд, аж ахуй нэгж байгууллагуудаас өргөдөл гомдол ирээгүй байна. Байгууллагын албан хаагчдаас төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгуулахаар, нэг удаагийн буцалтгүй тусламж хүссэн, хүүхэд асрах чөлөөтэй эх ажилдаа эргэж орох тухай 3 өргөдөл ирснийг бүртгэж холбогдох албан тушаалтанд шилжүүлж шийдвэрлүүлсэн байна.

ABLE программыг 12 албан хаагч өдөр тутмын үйл ажиллагаандаа байнга ашиглаж байна. Цаг бүртгэл хийх, Ажил хэрэг цэсэд өдөр тутмын ажлаа тайлагнах, ҮАГ-аас ирүүлж буй зар мэдээг хүлээн авах, албан бичгийн харилцаа, бичиг төлөвлөлт, удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, дотоод файлын санг ашиглан ажиллалаа. Тайлант хугацаанд ирсэн 9, явсан 6 албан бичиг, 2 өргөдлийг ABLE системд бүртгэсэн байна.

5.4. Шинэ санаачилга

МУЕА-ын 2023 оны А/173 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын тухай хуульд нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулах ажлын хэсгийн хуралдаан 2024.01.19, 2024.01.23-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулсанд саналаа бэлтгэж оролцлоо.

ҮАГ-аас "Нэгдсэн сургалт 2024"-ийг Төв аймагт 2024 оны 03 дугаар сарын 04-нд зохион байгууллаа. Сургалтад 11 албан хаагч хамрагдаж, нэгдсэн сургалтын хөтөлбөрийн хүрээнд 10 сэдвээр хичээл зааж, багаар дасгал, кейс ажлуулан, дүгнэж, сертификат олголоо. Сургалтыг үр дүнтэй зохион байгуулсан талаар ҮАГ-ын цахим хуудас болон байгууллагын цахим хуудсанд мэдээллийг байршуулан олон нийтэд хүргэлээ. ҮАГ-аас "Төрийн аудит иргэдийн амьдралд" танилцуулга материал ирүүлснийг 75 төрийн албан хаагч болон иргэдэд тарааж, сурталчлан танилцуулж ажиллалаа.



Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэсэн аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх, нэгтгэх, модуль системийг нэвтрүүлж,



санхүүгийн тайлангийн аудитын fas.audit.mn системтэй уялдуулснаар шалгадагч байгууллагаас аудитын шийдвэрийн биелэлтийг тайлагнах, хяналт тавих ажлыг хэрэгжүүлэхэд харилцагч байгууллагуудтай өдөр бүр харилцаатай ажиллаж байна.

Org.audit.mn системд шалгадагч 371 байгууллагын мэдээллийг хур системээс татаж болон нэмж байршуулсан. Fas.audit.mn системийн аудитын сэдэв сонголтын модульд 2024-2025 онд санхүүгийн тайлангийн аудитад хамрагдах 371 байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр, аудитын сэдэв сонголтыг системд байршуулах ажлыг 2024 оны 06 дугаар сарын 07-нд хэрэгжүүллээ.

ММНБИ-ээс зохион байгуулсан Аудиторын эрх олгох сургалтад дарга, тэргүүлэх аудитор, хоёр аудиторын хамт хамрагдаж, шалгалтаа амжилттай өгч, Аудиторын эрхийн гэрчилгээг 2024 оны 06 дугаар сарын 19-нд гардан авлаа.

Инженер геодези ХХК-аас зохион байгуулсан "Газрын тухай хуулийн хэрэгжилт гүйцэтгэлийн аудитад шинэ технологи дрон ашиглах" сэдэвт сургалтад дарга, тэргүүлэх аудитор, хоёр аудиторын хамтаар суралцаж, мэдлэгээ дээшлүүллээ.

Эрсдэл бууруулах хариу арга хэмжээний хүрээнд Дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны А/21 дүгээр тушаалаар "Дотоод хяналт шалгалтын ажлын хэсэг"-ийг 3 хүний бүрэлдэхүүнтэй томилсон. Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулан 3 дугаар улиралд дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

5.6. Бусад ажлын хүрээнд

Байгууллагын 2024 оны эхний хагас жилийн статистик мэдээ, үйл ажиллагааны тайланг гарган УАГ-ын ЗХЭЗГ, ДАХШҮГ, ХБТГ-т 2024 оны 07 дугаар сарын 05-нд хүргүүлэв. Мөн байгууллагын үйл ажиллагааны танилцуулга бэлтгэн Төв аймаг дахь Төрийн аудитын газрын facebook-д эхний хагас жилээр байршуулан, олон нийтэд мэдээлэл түгээн ажиллалаа.



Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлийн тайланг, нотлох баримтын хамт 2024 оны 04 дүгээр сарын 05-нд, 2 дугаар улирлын гүйцэтгэлийн тайланг 2024 оны 07 дугаар сарын 05-нд ДАХШҮГ, ЗХЭЗГ-т хүргүүллээ.

УИХ-ын 39 дүгээр тогтоолын дагуу албан хаагчдын цалинг 2024 оны 6 дугаар сарын 01-ээс нэмэгдүүлэн тооцон олгож байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар 369 байгууллагад, гүйцэтгэл, нийцлийн 3 аудитад хамрагдсан 374 байгууллагад аудит эхлэх тухай бүрд нөлөөллийн мэдүүлэг танилцуулан гарын үсэг зуруулж баталгаажууллаа.

Хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах 12 албан тушаалтнуудын нэрсийн жагсаалтыг 2024 оны 01 дүгээр сарын 02-нд гарган дээд шатны ЭБАТ-д хүргүүллээ. 2023 оны ХАСХОМ-ийг 2024 оны 02 дугаар сарын 01-ний дотор 11 албан тушаалтнаар, гаргуулан баталгаажууллаа. Санхүү, гүйцэтгэлийн аудит эхлэх тухай бүрд ашиг сонирхлын мэдэгдлийг тэргүүлэх аудитор, аудитын менежер, аудиторуудаар гаргуулан ажиллалаа. Авилгын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөний АНТАГ-тай хамаарал бүхий 16 заалтын 1 дүгээр улирлын хэрэгжилтийн тайланг 2024 оны 03 дугаар сарын 30, 2 дугаар улирлын тайланг 2024 оны 06 дугаар сарын 25-нд ЗХЭЗГ, ДАХШҮГ-т хүргүүллээ.

Байгууллагын ЭБАТ нь "ХАСХОМ мэдүүлэхэд анхаарах асуудал, Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх" сэдвээр дотоод сургалтыг 2024 оны 01 дүгээр сарын 22-нд хийж, албан хаагч нар бүрэн хамрагдлаа. "Авилгаас урьдчилан сэргийлье"



сурталчилгааны самбарыг тогтмол ажиллуулж, АТГ-ын соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн зурагт хуудсыг улиралдаа нэг шинэчлэн байршуулж байна. Төв аймаг дахь Төрийн аудитын газар цахим хуудсанд авлигын эсрэг 10 контент байршуулан, олон нийтэд мэдээлэл хүргэж ажиллалаа.

Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Нууцын хадгалалт хамгаалалтын чиглэлээр 2023 онд хэрэгжүүлсэн ажлын тайланг Тагнуулын ерөнхий газрын Төв аймаг дахь хэлтэст хүргүүллээ.

Байгууллагын нууцын бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлж, нууцын тэмдэг, хадгалах сейф, интернэтийн сүлжээнд холбогдоогүй компьютер ашиглаж байна. Нууцын баталгааг 12 албан хаагчаар гаргууллаа. Төрийн болон албаны нууцлалд хамаарах байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт холбогдох албан бичиг, баримт материал, санхүүгийн тайланг нууцын ажилтан зохих журмын дагуу бүртгэж, хадгалан, хамгаалан ажиллаж байна. Гадаад улсад зорчсон 2 аудитораар хүсэлт, илтгэх хуудас бичүүлсэн.

Байгууллагын үйл ажиллагаанд дараах программ, цахим системийн ашиглаж байна.Үүнд:

- Тайлант хугацаанд 2 аудитор ахлах аудитор, 1 үүрэг гүйцэтгэгч аудитораар дэвшин томилогдсоныг Хүний нөөцийн бүртгэлийн программд шинэчлэн бүртгэлээ.
- ABLE программыг 12 албан хаагч өдөр тутмын үйл ажиллагаандаа байнга ашиглаж байна. Цаг бүртгэл хийх, Ажил хэрэг цэсэд өдөр тутмын ажлаа тайлагнах, ЯАГ-аас ирүүлж буй зар мэдээг хүлээн авах, албан бичгийн харилцаа, бичиг төлөвлөлт, удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, дотоод файлын санг ашиглан ажиллалаа.
- Оффис 365 программыг аудитын менежер, мэдээлэл технологи хариуцсан ажилтан нар үйл ажиллагаандаа ашиглаж байна.
- Тайлант хугацаанд 369 байгууллагын санхүүгийн тайлангийн аудитыг fas.audit.mn системийг ашиглан аудитын үе шат бүрээр бүрэн гүйцэтгэж, ахлах аудитор, аудитын менежер, тэргүүлэх аудитор тухай бүрд нь хяналтыг хэрэгжүүлж, шалгагдагч байгууллагаас аудитын шийдвэрийн биелэлтийг тайлагнах, хяналт тавих ажлыг хэрэгжүүлэн ажиллалаа.
- Гүйцэтгэл, нийцлийн аудитын системд буюу Power apps программын Mongolian National Audit System V3 системд тайлант хугацаанд гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитын үе шатны ажлуудыг байршууллаа.
- Аудитын сэдэв сонголтын org.audit.mn системд 371 байгууллагын мэдээллийг "Хур" системээс татаж, бусад нэмэлт мэдээлэл буюу улсын бүртгэлийн дугаар, банкны нэр, дансны дугаар, байнгын хорооны ангилал, дарга, нягтлан бодогчийн овог, нэр, томилогдсон огноо, томилсон тушаалын дугаар зэргийг орууллаа.
- "Аудитын сэдэв сонголтын модуль"-д татагдсаны дагуу санал дүгнэлт гаргах 85, үе шатны ажлыг хэсэгчлэн хийх 204, аудитын хуулийн этгээдээр гэрээгээр гүйцэтгүүлэх 82 байгууллагын сэдвийн сонголтыг хийж, баталгаажууллаа.
- Акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх, нэгтгэх, модульд 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, биелэлтийг оруулж, хэрэгжилтийг шалгагдагч байгууллагын нягтлан бодогч, холбогдох албан тушаалтнаар гаргуулж, нотлох баримтыг хавсаргуулан хяналт тавин ажиллаж байна.
- Статистик мэдээний системд 2023 оны статистик мэдээ, аудитын шийдвэрийн үлдэгдлийг шивж оруулсан. fas.audit.mn системд 2024 онд санхүүгийн тайлангийн аудит хийсэн 369 байгууллагын үе шатны ажлуудыг 100 хувь бүртгэж, Гүйцэтгэл, нийцлийн аудитын системд эхний хагас жилд гүйцэтгэсэн 2 аудитын үе шатны ажлыг оруулснаар эхний хагас жилийн статистик мэдээг системрүү татаж, нэгтгэх боломжтой болсон.
- Гүйцэтгэлийн аудитын data.audit.mn системд тайлант хугацаанд гүйцэтгэсэн 3 гүйцэтгэл, нийцлийн аудитын явцын мэдээллийг 14 хоног тутамд байршууллаа.



- Open.audit.mn нээлттэй портал сайтад 2023 онд хураангуй 206, дэлгэрэнгүй 209, визуал 3 тайлан байршууллаа.
- Viber, teams, zoom, able, audit.mn системүүдийг ашиглан ҮАГ-тай мэдээ, мэдээлэл солилцон ажиллалаа.
- ЗГ-ын erp.e-mongolia.mn цахим портал сайтаар шалгагдагч болон хамрагдагч байгууллагатай мэдээллийг солилцож, хамтран ажиллав.

ЗУРГАА. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

МУЕА-ын 2020 оны А/100 дугаар тушаалаар батлагдсан НББ бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. 2024 оны 2 дугаар улирлын байдлаар 497.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 497.5 сая төгрөгийн санхүүжилт авч төсвийн гүйцэтгэл 418.7 сая төгрөг буюу 84,2 хувьтай байна.

Байгууллагын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд "Мишээл-Од аудит" ХХК-иар аудит хийлгэж, "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт авлаа.



Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг дараа сарын 2-ны дотор гаргаж аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээр баталгаажуулан ҮАГ-ын СХОХ-т хүргүүлж, Сангийн яамны э-тайлан системд шивлээ. Нийгмийн даатгалын тайланг сар бүр, ХХОАТ-ын улирлаар гарган цахим системээр хугацаанд нь илгээн ажиллаж байна.

Төсвийн зарлагын гүйлгээг Finance.gov.mn цахим системээр хийж гүйцэтгэж байна. 2025 оны төсвийн төслийг хийж 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 01/292 дугаар албан бичгээр

Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.

Шилэн дансны шинэ систем /gar.mof.gov.mn/-д мэдээлбэл зохих 163 мэдээллээс мэдээлэх хугацаа болсон 82 мэдээллийг хуулийн хугацаанд нь мэдээлсэн. Шилэн дансны тайланг улирал бүр хугацаанд нь илгээж байна. Мөн төсвийн гүйцэтгэл болон холбогдох мэдээллийг байгууллагын ил тодын самбарт тухай бүр байршуулан, олон нийтэд мэдээлэл хүргэж ажиллалаа. Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилт 100 хувь байна.

ДОЛОО. ДҮГНЭЛТ, САНАЛ

Дүгнэлт:

Төв аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 онд Төрийн аудитын байгууллагын хэмжээнд дэвшүүлсэн "Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангахад харилцагч талуудын оролцоог сайжруулах жил" зорилтын хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 10 зорилт 40 хэрэгжүүлэх арга хэмжээтэй боловсруулан батлуулж, эхний хагас жилд хийхээр төлөвлөсөн ажлыг 100 хувийн биелэлттэй хэрэгжүүлэн ажиллалаа.

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.6-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/75 дугаар "Санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай" тушаалын дагуу Төв



аймаг дахь Төрийн аудитын газраас 369 шалгагдагч байгууллагын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж, дүн, дүгнэлт гаргалаа.

Тайлант хугацаанд "Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн", "Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" гүйцэтгэлийн аудит, "Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох" сэдэвт нийцлийн аудитыг стандарт, журам, заавар аргачлалыг мөрдөн хийж, аудитын тайланг холбогдох байгууллагуудад хүргүүллээ.



Тайлант онд гүйцэтгэсэн аудитаар нийт 141,558.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 57,917.2 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 749.8 сая төгрөгийн зөрчилд 148 төлбөрийн акт, 39,592.8 сая төгрөгийн 190 албан шаардлага, 43,298.2 сая төгрөгийн 410 зөвлөмж, сахилгын шийтгэл ногдуулахаар 18 албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлж, хэрэгжилтийг тооцон ажиллалаа.

Дотоод сургалтын төлөвлөгөөнд эхний хагас жилд хийхээр тусгагдсан 13 сэдвээр сургалтыг хийж, тайланг УАГ-ын ХБТГ-т 2024 оны 07 дугаар сарын 02-нд хүргүүллээ.

ММНБИ-ээс зохион байгуулсан Аудиторын эрх олгох сургалтад дарга, тэргүүлэх аудитор, хоёр аудиторын хамт хамрагдаж, шалгалтаа амжилттай өгч, Аудиторын эрхийн гэрчилгээг 2024 оны 06 дугаар сарын 19-нд гардан авлаа.

УАГ-аас 21 удаагийн сургалт, ММНБИ, Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэнцэх газар, Цахим хөгжлийн яам, Боловсрол шинжлэх ухааны газар, Инженер геодези ХХК зэрэг байгууллагуудын 7 удаагийн сургалтад албан хаагч нар бүрэн хамрагдаж, мэдлэгээ дээшлүүллээ.

Санал:

Төв аймаг нь газар зүйн байршлын хувьд Улаанбаатар хотыг тойрсон, Засаг захиргааны нэгжийн тоо улсын хэмжээнд хамгийн олон буюу 27 сумтай учраас аудит хамрагдах байгууллага, хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнүүд олон байдаг. Мөн Шинэ нисэх онгоцны буудал, Шинэ Зуунмод дагуул хот зэрэг бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж байгаа онцлогтой юм. Үүнээс шалтгаалан санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэл, нийцлийн аудитад хамрагдах байгууллагын тоо олон байдаг тул ажлын ачаалал их, ажиллах хүний нөөц дутмаг байгаа асуудлыг шийдвэрлэн 2 орон тоо нэмэгдүүлэх санал хүргүүлж байна.

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР.....(Ц.ХИШИГЖАРГАЛ)

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

АУДИТЫН МЕНЕЖЕР.....(О.АМАРЖАРГАЛ)